ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# Өмнөговь аймгийн Ханхонгор сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ӨМА-2025/097/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.Umnugovi@audit.mn<br>Өмнөговь аймаг<br><br>2025 он | Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр<br>Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Т.Хонгорзул<br>Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Ж.Болормаа<br>Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт** /Баталгаажсан хувийг оруулах/

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.02.25 № 70

танай ______________-ны №______________ -т

ХАНХОНГОР СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Ц.МӨНХДАЛАЙ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ханхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Орон нутгийн сонгуулийг хуулийн дагуу зохион байгуулагдаж шинэ хурлын төлөөлөгчид сонгогдон, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас чадавхжуулах сургалтыг зохион байгуулсанд хамруулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд Улсын Их Хурлын гишүүний өгсөн 1 хөрөнгийг бүртгэлд тусгасан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 81 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний

4625020174

хэрэгжилтийг 84.5 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБАЯР

F:\2.Бичиг хэрэг\2025он\СТА-н дүгнэлт\Төсөл.Docx

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **I** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **10,747,970.00** | **9,070,820.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **10,747,970.00** | **9,070,820.00** |
| **354** | Хангамжийн материал | 10,747,970.00 | 9,070,820.00 |
| **3541** | Бичиг хэргийн материал | 1,449,050.00 | 477,000.00 |
| **3542** | Аж ахуйн материал | 8,785,920.00 | 8,123,820.00 |
| **3543** | Сэлбэг хэрэгсэл | 370,000.00 | 370,000.00 |
| **3544** | Түлш, шатах тослох материал | 143,000.00 | 100,000.00 |
| **II** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **31,902,934.02** | **25,426,030.79** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **31,902,934.02** | **25,426,030.79** |
| **392** | Биет хөрөнгө | 31,902,934.02 | 25,426,030.79 |
| **39205** | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 28,304,200.00 | 30,144,200.00 |
| **39206** | Хуримтлагдсан элэгдэл | (1,875,309.38) | (9,243,499.94) |
| **39207** | Тавилга, аж ахуйн эд хогшил | 12,010,180.00 | 11,610,000.00 |
| **39208** | Хуримтлагдсан элэгдэл | (6,536,136.60) | (7,084,669.27) |
| **III** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **42,650,904.02** | **34,496,850.79** |
| **V** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **42,650,904.02** | **34,496,850.79** |
| **51** | Засгийн газрын хувь оролцоо | 42,650,904.02 | 34,496,850.79 |
| **511** | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 19,368,627.00 | 19,368,627.00 |
| **51101** | Өмч: - төрийн | 19,368,627.00 | 19,368,627.00 |
| **512** | Хуримтлагдсан үр дүн | 23,146,284.50 | 14,992,231.27 |
| **5121** | Өмнөх үеийн үр дүн | 23,146,284.50 | 20,678,057.54 |
| **5122** | Тайлант үеийн үр дүн | | (5,685,826.27) |
| **513** | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 135,992.52 | 135,992.52 |
| **VI** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **42,650,904.02** | **34,496,850.79** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **140,605,900.00** | **219,881,400.00** |
| **12** | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | | 6,065,000.00 |
| **120** | Нийтлэг татварын бус орлого | | 6,065,000.00 |
| **120017** | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 6,065,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **140,605,900.00** | **213,816,400.00** |
| **1311** | Нэмэлт санхүүжилтийн орлого | 8,870,000.00 | 9,734,200.00 |
| **131103** | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,870,000.00 | 9,734,200.00 |
| **1320** | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 131,735,900.00 | 204,082,200.00 |
| **132001** | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 131,735,900.00 | 204,082,200.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **143,057,503.02** | **225,567,225.99** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **143,057,503.02** | **225,567,225.99** |

| | | | |
|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **131,981,516.13** | **203,192,329.87** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **82,483,019.17** | **142,475,214.01** |
| **210101** | Үндсэн цалин | 46,404,142.49 | 64,296,103.38 |
| **210102** | Нэмэгдэл | 32,665,023.68 | 71,712,710.63 |
| **210104** | Урамшуулал | 3,413,853.00 | 6,466,400.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **9,720,491.94** | **17,564,796.87** |
| **210201** | Тэтгэврийн даатгал | 4,862,117.66 | 12,028,176.26 |
| **210202** | Тэтгэмжийн даатгал | 3,333,450.44 | 1,370,110.15 |
| **210203** | ҮОМШӨ-ний даатгал | 448,846.91 | 752,365.08 |
| **210204** | Ажилгүйдлийн даатгал | 100,305.85 | 666,233.08 |
| **210205** | Эрүүл мэндийн даатгал | 975,771.08 | 2,747,912.30 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **23,522,652.00** | **13,902,643.00** |
| **210401** | Бичиг хэрэг | 939,745.00 | 2,356,250.00 |
| **210402** | Тээвэр, шатахуун | 10,606,709.00 | 9,263,333.00 |
| **210403** | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 100,000.00 | 300,000.00 |
| **210406** | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 976,560.00 |
| **210407** | Аж ахуйн материал худалдан авах зардал | 11,876,198.00 | 1,006,500.00 |
| **2106** | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,116,200.00 | 1,749,000.00 |
| **210604** | Урсгал засвар | 1,116,200.00 | 1,749,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,486,000.00** | **2,046,000.00** |
| **210702** | Дотоод албан томилолт | 2,486,000.00 | 2,046,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **9,775,000.00** | **10,535,000.00** |
| **210801** | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,775,000.00 | 10,535,000.00 |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,878,153.02 | 14,919,675.99 |
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | 285,500.00 | 1,000,000.00 |
| **210902** | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 3,846,000.00 |
| **210903** | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 2,592,653.02 | 10,073,675.99 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **11,075,986.89** | **22,374,896.12** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **9,413,000.00** | **13,062,000.00** |
| **213208** | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 9,902,000.00 |
| **213209** | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,413,000.00 | 3,160,000.00 |
| **2134** | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,662,986.89 | 9,312,896.12 |
| **213403** | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,662,986.89 | 9,312,896.12 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-2,451,603.02** | **-5,685,825.99** |
| **225** | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 0.28 |
| **225001** | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | 0.28 |
| **IV** | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | | -0.28 |
| **V** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-2,451,603.02** | **-5,685,826.27** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **140,605,900.00** | **213,816,400.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **140,605,900.00** | **213,816,400.00** |
| **1311** | Нэмэлт санхүүжилтийн орлого | 8,870,000.00 | 9,734,200.00 |
| **131103** | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,870,000.00 | 9,734,200.00 |
| **1320** | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 131,735,900.00 | 204,082,200.00 |
| **132001** | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 131,735,900.00 | 204,082,200.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **137,705,900.00** | **213,816,400.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **137,705,900.00** | **213,816,400.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **126,472,913.11** | **191,441,503.88** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **82,054,925.06** | **142,474,514.01** |
| **210101** | Үндсэн цалин | 44,143,569.99 | 64,796,601.53 |
| **210102** | Нэмэгдэл | 32,530,594.91 | 64,599,103.38 |
| **210103** | Унаа хоолны хөнгөлөлт | | 1,371,759.10 |
| **210104** | Урамшуулал | 5,380,760.16 | 11,707,050.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **10,148,586.05** | **17,565,496.87** |
| **210201** | Тэтгэврийн даатгал | 7,019,392.00 | 12,028,176.26 |
| **210202** | Тэтгэмжийн даатгал | 846,393.77 | 1,370,310.15 |
| **210203** | ҮОМШӨ-ний даатгал | 651,884.53 | 752,165.08 |
| **210204** | Ажилгүйдлийн даатгал | 147,550.48 | 776,733.08 |
| **210205** | Эрүүл мэндийн даатгал | 1,483,365.27 | 2,638,112.30 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **11,105,902.00** | **11,415,093.00** |
| **210401** | Бичиг хэрэг | 831,950.00 | 1,397,000.00 |
| **210402** | Тээвэр, шатахуун | 9,524,152.00 | 9,220,333.00 |
| **210403** | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 300,000.00 | 300,000.00 |
| **210406** | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 449,800.00 | 497,760.00 |
| **2106** | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,481,200.00 | 1,749,000.00 |
| **210604** | Урсгал засвар | 1,481,200.00 | 1,749,000.00 |
| **2107** | Томилолт, зочны зардал | 2,486,000.00 | 2,046,000.00 |
| **210702** | Дотоод албан томилолт | 2,486,000.00 | 2,046,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **13,192,200.00** | **10,196,500.00** |
| **210801** | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,192,200.00 | 10,196,500.00 |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,004,100.00 | 5,994,900.00 |
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | 345,500.00 | 1,000,000.00 |
| **210902** | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,658,600.00 | 4,994,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **11,232,986.89** | **22,374,896.12** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **9,570,000.00** | **13,062,000.00** |
| **213208** | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 9,902,000.00 |
| **213209** | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,570,000.00 | 3,160,000.00 |
| **2134** | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,662,986.89 | 9,312,896.12 |
| **213403** | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,662,986.89 | 9,312,896.12 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **2,900,000.00** | |

| | | | |
|---|---|---|---|
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 2,900,000.00 | |
| | Дотоод эх үүсвэрээр | 2,900,000.00 | |
| 223001 | Бусад хөрөнгө | 2,900,000.00 | |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -2,900,000.00 | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | ЗГ-н хувь оролцооны дүн |
|---|---|---|---|---|---|
| **10** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **19,368,627.00** | **135,992.52** | **23,146,284.50** | **42,650,904.02** |
| **11** | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | -2,468,226.96 | -2,468,226.96 |
| **12** | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 19,368,627.00 | 135,992.52 | 23,146,284.50 | 42,650,904.02 |
| **17** | Тайлант үеийн үр дүн | | | -5,685,826.27 | -5,685,826.27 |
| **19** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **19,368,627.00** | **135,992.52** | **14,992,231.27** | **34,496,850.79** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **204,793,700.00** | **194,769,303.88** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **204,793,700.00** | **194,769,303.88** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **193,753,500.00** | **184,167,303.88** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **143,868,300.00** | **136,008,614.01** |
| **210101** | Үндсэн цалин | 64,946,300.00 | 64,796,601.53 |
| **210102** | Нэмэгдэл | 64,673,500.00 | 64,599,103.38 |
| **210103** | Унаа хоолны хөнгөлөлт | 3,688,500.00 | 1,371,759.10 |
| **210104** | Урамшуулал | 10,560,000.00 | 5,241,150.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **17,862,900.00** | **16,757,196.87** |
| **210201** | Тэтгэврийн даатгал | 11,331,200.00 | 11,451,932.26 |
| **210202** | Тэтгэмжийн даатгал | 1,333,100.00 | 1,305,546.15 |
| **210203** | ҮОМШӨ-ний даатгал | 2,265,800.00 | 652,673.08 |
| **210204** | Ажилгүйдлийн даатгал | 266,600.00 | 763,173.08 |
| **210205** | Эрүүл мэндийн даатгал | 2,666,200.00 | 2,583,872.30 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **11,429,900.00** | **11,415,093.00** |
| **210401** | Бичиг хэрэг | 1,400,000.00 | 1,397,000.00 |
| **210402** | Тээвэр, шатахуун | 9,229,900.00 | 9,220,333.00 |
| **210403** | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 300,000.00 | 300,000.00 |
| **210406** | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 500,000.00 | 497,760.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,750,000.00** | **1,749,000.00** |
| **210604** | Урсгал засвар | 1,750,000.00 | 1,749,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,064,600.00** | **2,046,000.00** |
| **210702** | Дотоод албан томилолт | 2,064,600.00 | 2,046,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **10,777,800.00** | **10,196,500.00** |
| **210801** | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,777,800.00 | 10,196,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **6,000,000.00** | **5,994,900.00** |
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **210902** | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,000,000.00 | 4,994,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **11,040,200.00** | **10,602,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **11,040,200.00** | **10,602,000.00** |
| **213208** | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 10,540,200.00 | 9,902,000.00 |
| **213209** | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 500,000.00 | 700,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **204,793,700.00** | **213,395,096.12** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **204,793,700.00** | **213,395,096.12** |
| **132001** | Орон нутгийн төсвөөс | 204,793,700.00 | 213,395,096.12 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | - | **3** |
| **620001** | Удирдах ажилтан | - | 1 |
| **620002** | Гүйцэтгэх ажилтан | - | 2 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **9,734,200.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **9,734,200.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **7,274,200.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **6,465,900.00** |
| **210104** | Урамшуулал | 6,465,900.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **808,300.00** |
| **210201** | Тэтгэврийн даатгал | 576,244.00 |
| **210202** | Тэтгэмжийн даатгал | 64,764.00 |
| **210203** | ҮОМШӨ-ний даатгал | 99,492.00 |
| **210204** | Ажилгүйдлийн даатгал | 13,560.00 |
| **210205** | Эрүүл мэндийн даатгал | 54,240.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,460,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **2,460,000.00** |
| **213209** | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,460,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **9,734,200.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **9,734,200.00** |
| **131103** | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 9,734,200.00 |

**Гурав. Аудитын илрүүлэлт:** Аудитаар нийт 5,497.5 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад алдааг залруулсан.

*Залруулсан алдаа:*

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын дүнг үндсэн хөрөнгийн тайланд 2,725.0 мянга, цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг өглөгийг 500.0 мянга, дотоод албан томилолтын зардлыг 822.0 мянган төгрөгөөр зөрүүтэй
- Тээвэр шатахууны 500.0 мянган төгрөгийг цалингийн зардлаар бүртгэсэн, бусдаар гүйцэтгүүлсэн зардлаас 847.0 мянган төгрөгийн шатахууны зардлыг авч шууд зардлаар зарцуулж, эдийн засгийн ангилал зөрчсөн
- Түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт 3 албан хаагчид олгохдоо 103.5 төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл тооцоогүй нь УСНББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга" болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгааг залруулав.

Аудитаар илэрсэн нийт 498.0 мянган төгрөгийн зөрчлийг илрүүлж, 498.0 мянган төлбөрийн акт, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн ил тод байдлыг хангах зөвлөмж өглөө.

**3.2 Төлбөрийн акт**

1. Байгууллагын дотоод журмаар тэтгэмж олгохдоо 98,000 төгрөгийн албан татвар суутгаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар,...",* Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дугаар тушаалын хавсралт "Хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх, албан татварын хөнгөлөлт эдлүүлэх журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2-д *"Суутган төлөгч нь хууль тогтоомжид тусгайлан заагаагүй “Хөдөлмөрийн дотоод журам” зэрэг зөвхөн тухайн байгууллагын баримт бичиг, шийдвэрийг үндэслэн олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламжийг албан татвараас чөлөөлөхгүй"* гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

2. Шинэ жилээр ажилчдын хүүхдүүдэд 100.0 мянган төгрөгийн бэлэг, чөлөөлөгдсөн төлөөлөгч нарт 300.0 мянган төгрөгийн бэлгийн багц өгсөн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1."*Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно*", 15 дугаар зүйлийн 15.1.5 "*төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах*" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна

**3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

***1.1. Илрүүлэлт****:* Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлогын 28,099.8 мянган төгрөгийн 2 гүйлгээ мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 "Энэ хуулийн 6.1.2-т заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна", 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр " заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

***Өгсөн зөвлөмж*****:** Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн ил тод мэдээллийг хангаж цаг хугацаанд нь мэдээлж байх .

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 10 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Д.д | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын дүнг үндсэн хөрөнгийн тайланд 2,725.0 мянга, цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг өглөгийг 500.0 мянга, дотоод албан томилолтын зардлыг 822.0 мянган төгрөгөөр зөрүүтэй | 3 | 4,047.0 | | | 3 | 4,047.0 | 3 | 4,047.0 | | | | |
| 2 | Тээвэр шатахууны 500.0 мянган төгрөгийг цалингийн зардлаар бүртгэсэн, бусдаар гүйцэтгүүлсэн зардлаас 847.0 мянган төгрөгийн шатахууны зардлыг авч шууд зардлаар зарцуулж, эдийн засгийн ангилал зөрчсөн | 1 | 1,347.0 | | | 1 | 1,347.0 | 1 | 1,347.0 | | | | |
| 3 | Түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт 3 албан хаагчид олгохдоо 103.5 төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл тооцоогүй | 1 | 103.5 | 1 | 103.5 | | | 1 | 103.5 | | | | |
| | **Дүн** | **5** | **5,497.5** | **1** | **103.5** | **4** | **5,394.0** | **4** | **5,394.0** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Д.д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | Байгууллагын дотоод журмаар тэтгэмж олгохдоо албан татвар суутгаагүй байна. | 1 | 98.0 | 1 | 98.0 | | | | | | | | |
| | **Дүн** | **1** | **98.0** | **1** | **98.0** | | | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Д.д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс |
|---|---|---|---|

| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | **Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | | | | | |
| 1 | Шинэ жилээр ажилчдын хүүхдүүдэд бэлэг, чөлөөлөгдсөн төлөөлөгч нарт бэлгийн багц өгсөн байна | 1 | 400.0 | 1 | 400.0 | | | | | | | | |
| | **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | | | | | |
| 1 | Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлогын 28,099.8 мянган төгрөгийн 2 гүйлгээ мэдээлээгүй | **1** | **0** | | | | | 1 | 0 | | | | |
| | **НИЙТ ДҮН** | **3** | **498.0** | **2** | **498.0** | | | **1** | **0** | | | | |